

## 1956 ОНЫ IV БҮГД ХУРАЛ ДЭЭР Ц.ЛООХУУЗЫН ТАВЬСАН ШҮҮМЖЛЭЛИЙН ТУХАЙД

Б.Баттөмөр

Шинжлэх Ухааны Академийн Түүхийн Хүрээлэн.

**Өгүүллийн товч утга:** Би энэ өгүүлэлдээ Ц.Лоохуузын өөрийнх нь шүүмжлэлийг гол болгон тусгахын сацуу тус бүгд хуралд оролцогчид Ц.Лоохууз ба түүний шүүмжилсэн албан тушаалтнуудын ажлын арга барил дутагдлын тухайд тус бүгд хурлын гишүүд хэрхэн хандаж байсныг харуулах зайлшгүй тодруулах шаардлагатай уялдаж байна. Өөрөөр хэлбэл Ц.Лоохуузын шүүмжлэлийн тухай бусад хүн ямар байр суурьтай байгааг харуулахын тулд ингэж бичсэн болохоо зориуд тэмдэглэж байна.

**Түлхүүр үг:** Тахин шүтэх, шүүмжлэл, шинэ хүчин.

Түүхийн аль нэгэн сэдэв, асуудлыг судлахад тулгуурлах гол зүйл бол сурвалж байдаг билээ. Ялангуяа орчин үеийн Монголын улс төрийн түүхийг тал бүрээс нь тодруулан шинжлэхийн тулд юуны өмнө тус орны эрх баригч цор ганц нам-МАХН-ын дотоод үйл ажиллагаа, намын удирдах ажилтнуудын тухай судлах явдал нэн чухал болж байна. Нийгэм улс төрийн аливаа үйл явдал заавал эзэн биетэй байдаг учраас түүхийн аль нэгэн асуудлыг нэхэн тодруулахад түүхэн зүтгэлтнүүдийн бичгийн өв санг шавхан үзэх нь онцгой учир холбогдолтой билээ.

Чухам энэ үүднээс 1956 онд буюу одоогоос хагас зууны тэртээ болсон МАХН-ын Төв Хорооны ээлжит бүгд хурал дээр Говь-Алтай аймгийн намын хорооны I нарийн бичгийн дарга Цогт-Очирын Лоохуузын хэлсэн үг буюу шүүмжлэлийг сурвалж судлалын үүднээс нэхэн судлахыг хичээлээ.

Тус хурал дээр тэрбээр шүүмжлэхдээ тухайн үед улс орны өмнө тулгамдсан зорилт болж байсан хэд хэдэн томоохон асуудлыг хөндсөн бөгөөд түүний шүүмжлэлийг тус бүгд хуралд оролцогчидын олонхи нь нааштай хүлээн авсан байна. Энэ шүүмжлэл өдгөө Монгол Ардын Хувьсгалт Намын Төв архив (Ф-4, т-23, х/н-1)-т хадгалагдаж байна. Жич: Шүүмжлэлийг анхааран үзвэл, сүүлд нь нягтлан уншсан болов уу гэмээр харандаа, хөх өнгийн бэхээр зассан байх ба шүүмжлэл бүрийн сүүлд бичсэн, тулгасан хүний нэрс байх боловч Лоохуузын шүүмжлэлийг бичсэн хүний нэр гарын үсэг огт байхгүй ба зөвхөн /0017,5/ гэсэн бичээчийн код л байгаа юм. Эл шүүмжлэл нь тухайн үед МАХН-д ардчилал ихээхэн хязгаарлагдмал, хатуу хяналттай байсныг өөрчлөх зорилгоор Ц.Лоохууз ийнхүү нэлээд хурц, дайчин, бодитой шүүмжлэлийг сайтар бэлтгэж тавьсны үр дүн байлаа. Гэхдээ зарим цөөн хүн Ц.Лоохуузын шүүмжлэлийг эсэргүүцсэн байдаг нь тэр үед МАХН-ын удирдлагад улс төрийн бүлэглэлүүд байсантай холбоотой бизээ.

Тус бүгд хуралд НТХ-ны I нарийн бичгийн дарга нөхөр Д.Дамбын тавьсан илтгэлийг Ц.Лоохууз шүүмжлэлийнхээ эхэнд тэмдэглэсэн байна. Тухайлбал, И.В.Сталиныг тахин шүтэж байсны сөрөг үр дагаварыг Д.Дамба илтгэлдээ тодорхой тэмдэглэсэн атлаа Монголд буюу МАХН-д ямар хохирол учруулсан бэ гэдгийг хэлсэнгүй. Миний бодоход И.В. Сталиныг тахин шүтсэний уршгаар Монголд нэлээд сөрөг үр дагавар бий болсон. Жишээ нь: "...монголын малыг 200 сая толгойд хүргэх хэрэгтэй гэсэн түүний үгийг манай нам өргөн дэвшүүлсэн удаа бийгээр барахгүй улмаар монголын малыг 50 сая 31 сая болгоно гэсэн лозунг удаа дараа гаргажээ. Зохих цаг ба нөхцөл байдалдаа биелүүлж болсонгүй. Ийм лозунг дэвшүүлэн гаргасан нь үнэн хэрэг дээрээ ноцтой алдаа болсон, өргөн олон түмний дотор намын нэр хүндийг гутаасан зүйл болсон" гэжээ. Цааш нь өгүүлэхдээ: "ЗХУКН-ын XX их хурлын дүнгийн тухай асуудлыг тус бүгд хуралд хэлэлцэж байгаа нь манай намын үйл ажиллагаанд

хэмжээлшгүй их ач холбогдолтой”<sup>1</sup>-г тэмдэглэхийн хамт “...Х.Чойбалсанг тахин шүтэх явдлыг дэмжиж хувийн алдар нэр зэрэг хэргэмийг эрхэмлэн хөөцөлдөх хүн УТТ-ны гишүүдийн дотор байна уу, үгүй юу, Сталин, Чойбалсан нар өөрсдийгөө шүтэж биширч байхыг манайханд тулгаж байсан уу” гэсэн асуудал дэвшүүлжээ. Мөн “ЗХУКН-ын XX их хурал нь бид бүхэнд онол практикийн их сургамж өгч, нам ба олон түмний ашиг тусыг үнэнчээр эрхэмлэн хамгаалахын тод жишээг улам тод үзүүлснээрээ «манай намд цэвэр амьсгал оруулсан», намын удирдагчид, намын ажилтан нарын алдаа дутагдлаа мэдэх засах тухай их тус болох”<sup>2</sup>-ыг сануулжээ. Түүнчлэн нэг хүнийг тахин шүтэх явдлын чухам мөн чанарыг нээн илрүүлэх талаар “...хэрэв батлах баримтгүй юм бол тэднийг шүтэх бишрэх явдлыг хэрэг дээрээ бид нар манай намын удирдлага л санаачилснаас зайлах газаргүй. Тэгвэл энэ тухай яагаад өөрсдийнхөө бурууг хүлээж, тус бүгд хуралд тавихгүй байна вэ” гэсэн асуудлыг ч дэвшүүлэн тавьжээ. 1954 онд цагаатгагдсан “Порт-Артур”-ын хэргийг чухам санаачлагч буюу зөвшөөрсөн хүмүүсийн тухайд холбогдуулан хэлэхдээ: “Порт Артур”-ын хэрэг гэгч гарч байна. Энэ хэрэгт Дотоод яамны тэр үеийн удирдах хүмүүс буруу болж хоцров. Миний бодоход Дотоод яамны удирдах хүмүүс, Төв хорооны УТТ-ны толгой дээр алхаж, энэ асуудлыг шийдвэрлээгүй байхаа. Манай намын удирдагчдаас хэн нь мэдэх, хэн нь зөвшөөрсөн бэ? Үүнийг яагаад дурдахгүй байна”<sup>3</sup> гэж няглууштай асуудал маш их байгааг хөндөн тавьжээ.

Ц.Лоохууз ийнхүү тухайн үеийн Монголын нийгэм дэх далд нуугдан буй тодорхой бус асуудлуудын чухам цаад эзэн нь хэн бэ, түүний чухам учир шалтгааныг нээн илрүүлэх талаар хурц шүүмжлэл өрнүүлсэн нь бусад шүүмжлэл тавьсан хүмүүсийнхээс нэлээд онцлог, ялгаатай байна.

Ц.Лоохуузын шүүмжлэлд байгаа бас нэг сонин зүйл бол Х.Чойбалсанг нас барсны дараа Монголын Засгийн Газрыг хэн тэргүүлэх асуудлаас болж, манай удирдагчдын хооронд хурц тэмцэл өрнөснийг тэмдэглэсэн явдал юм. Тэрбээр шүүмжлэхдээ: “...Ерөнхий сайдыг томилох явдал дээр УТТ-ны гишүүдийн зарим нь Ерөнхий сайдад Цэдэнбалыг, зарим нь Сүрэнжавыг гэж гишүүд санал хуваагдан хүч тэнцэж, төвөгтэй байдал байсан гэж дуулсан. Ийм байдалд нөхөр Цэдэнбалыг Ерөнхий сайд болгох санаатай байсан Дамбаас “... чамайг бүгд хурлаар хэлэлцүүлнэ гэх зэргээр Сүрэнжавыг айлган байж хүчний харьцааг өөрчлөн уг асуудлыг шийдвэрлэсэн гэдэг. Тэгээд энэ сүрхий чармайлтынхаа ачаар Дамба нэгдүгээр нарийн бичгийн дарга болж дэвших бололцоог олж авсан. ...Ерөөсөө Ерөнхий сайдыг томилох асуудал бүгд хурлаар биш, тэнцүү тоотой, улс төрийн товчооны гишүүдийн хурлаар шийдвэрлэх хэрэгтэй болсон юм бэ? Энэ асуудлыг одоо болтол намын олон түмэнд юуны өмнө намын хорооны бүгд хуралд сонсгоогүй байна вэ”<sup>4</sup> гэсэн асуудал дэвшүүлжээ.

Лоохуузын дээрх шүүмжлэл үнэхээр бодитой зүйлийг ярьсан уу, эсвэл оргүй зүйлийг зохион хэлсэн үү гэдэг нь эргэлзээ төрүүлж байх мэт. Гэвч тус бүгд хуралд оролцогчдоос /Бавуудоржоос бусад нь/ чухам энэ асуудлын талаар нэг ч үг хэлээгүй буюу Ц.Лоохууз худал ярьж байна гэж түүнийг эсэргүүцээгүйгээс үзэхэд Ю.Цэдэнбал ба Ч.Сүрэнжав хоёр Ерөнхий сайдын албан тушаал эзлэхийн тулд нэлээд хүчтэй сөргөлдөх болсон төдийгүй тэр хоёрыг дэмжсэн бүлэглэл ч үүссэн байж магадгүй аж. Ямар ч байсан Д.Дамба Ю.Цэдэнбалыг дэмжихдээ Ч.Сүрэнжавыг янз бүрээр айлган сүрдүүлж байсан нь үнэн бололтой. Д.Дамба Ю.Цэдэнбалыг тууштай дэмжсэн нь ч бас л зохих шалтгаантай байсан аж. Тодруулбал Д.Дамба Ю.Цэдэнбалыг дэмжиж Ерөнхий

<sup>1</sup> Монгол Ардын Хувьсгалт Намын Төв архив (Цаашид МАХН гэх). Ф-4, т-23, х/н-1.т-209

<sup>2</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.т-209

<sup>3</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-211

<sup>4</sup> Мөн тэнд.т-210-212

сайд болгосныхоо «шагналд» өөрөө албан тушаал ахиж, МАХН-ын Төв Хорооны I нарийн бичгийн даргын суудалд хүрч чадсан байна. Энэ нь 1952 онд БНМАУ-ын Ерөнхий сайдыг томилох тухай шийдвэрийг МАХН-ын ТХ-ны бүгд хурлаар бус зөвхөн Улс Төрийн Товчооны хурлаар шийдвэрлэсэнээр батлагдаж байна.

Монголын гадаад харилцааны асуудлыг Ц.Лоохууз шүүмжлэхдээ тухайн үед төр засгаас зайлшгүй хөндөх буюу анхаарууштай сэдвийг цохон тэмдэглэжээ. Тухайлбал, "...гадаад улстай холбогдсон тэнд явсан асуултуудыг намын бүгд хуралд таниулах, бүгд хурлын сонор сэрэмжид хүргэж байх нь их хэрэгтэй байна. Ер нь манай намын гадаад бодлого муу анхаарагдаж байгаагаас энэ талаар их цаг өнгөрүүлж зарим талаар алдах явдал ч байна. Учир нь манай намын гадаад бодлогод дутагдал ихээр бий бөгөөд үүнийг намын бүгд хурлаас шүүмжилж ярьж байх нь хэрэгтэй байна. Гадаад бодлогыг дутагдалтай явуулж буй нь тус улсыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад гишүүнээр орох, бусад олон улстай бие даасан идэвхитэй гадаад бодлого явуулахад муугаар нөлөөлж байна" хэмээн өгүүлжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлийн нэг онцлог нь нам, төрийн удирдах дээд байгууллага, намын удирдах зүтгэлтнүүдийн үйл ажиллагаанд гүнзгий шүүмжлэлтэй хандсан явдал юм. Тухайлбал, МАХН-ын удирдах албан тушаалтан зарим хүн ЗХУКН-ын XX их хуралд оролцож ирээд улс орны дотоодын байдалд урьд өмнөхөөсөө огт ондоо байр сууринаас хандаж ажиллах байх хэмээн хүлээж байсныгаа тэрбээр "...ялангуяа юуны урьд намын Төв Хорооны удирдах нөхдөд өөрсдөд нь байгаа алдар завшаан эрэх, нам ард түмэн, эх орны сонирхолоо мартахад хүрдэг хүнд суртал, зусар бялдууч явдалтай эрс шийдвэртэй тэмцэх арга замыг авах байх гэж тус бүгд хурлыг хүртэл намын олон түмэн хүлээж байлаа. Гэтэл Дамбын илтгэлийг сонссоны дараа бидний горьдлого бүтсэнгүй нь мэдэгдэв. Харин ч намын олон түмний мэдсээр байгаа бөгөөд өөрсөд дээр нь байгаа дутагдлыг мөн л хуучин аргаар бүгд хурлаас нууж өнгөрүүлэхийг оролдсон нь намд харамсалтай хэрэг. Манай нам үнэхээр марксизм-ленинизмыг тууштай дагадаг, бүтээлчээр хэрэглэдэг чанартай нам мөн юм бол намын хэрэгт иймэрхүү либерал маягаар хандахыг намын гишүүд бид тэсвэрлэж хэрхэвч болохгүй"<sup>5</sup>, түүнчлэн нэг хүнийг тахин бишрэхээс үүсч гарсан алдаа дутагдал, хор холбогдол манай намд үлэмж их байх бөгөөд энэ хортой онол манай намын ажилтан, намын гишүүдийн оюун мэдрэл, ажил хэрэгт амь бөхтэй зууралдан шингэсэн"-ийг тэмдэглээд "...энэ хортой онолоор гүнзгий хорлогдсон хүмүүс олон бий бөгөөд биеэ тоох, олон түмэн доод хүмүүсийн санал эрмэлзлэлийг сонсохгүй, гадуур тал татаж бие биеэ зусардах, бялдуучлах, олны итгэл хүлээсэн олны хяналт дор байгаагаа мартаж зэрэг энэ бүх үзэгдлүүд бол дээрх хортой онолын практикийн илрэл, шинж чанарууд нь мөн. Үүнийг арилгана гэдэгт маш шургуу тэмцэл хэрэгтэй. Нэг хүнийг тахин шүтэх явдлын хор холбогдол манай өнөөгийн практик ажиллагаанд ийм гүнзгий байгааг нөхөр Дамба илтгэлд хамруулж өгсөнгүй нь харамсалтай. ...нэг хүнийг шүтэх онол урьд байсан хүмүүст байсан гэж заагаад одоо байгаа удирдах хүмүүс энэ онолын талаар цэвэр мэт ойлголт төрүүлж байгааг тэмдэглэхийн хамт энэ нь тахин шүтэх явдлыг хүчтэй эсэргүүцэн тэмцэхэд саад болж байгаагаар барахгүй, цаашид үргэлжлүүлэх явдлаас нь болгоомжилж, чадахгүйд хүргэх хортой зүйл" гээд "...ер нь нэг хүнийг тахин шүтэх онолын нөлөө нь манай намын урьд өнгөрсөн үеэс дутахгүй өнөөдрийн үйл ажиллагаанд суурь үндэс ихтэй байгааг хэлэх хэрэгтэй"<sup>6</sup> гэдгийг цохон тэмдэглэжээ. Ийнхүү тус бүгд хурлаас намын өмнө тулгарч буй асуудлыг нэлээд

<sup>5</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-215-216

<sup>6</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-212-215

бодитойгоор авч үзэж, олон түмний сонорт хүргэх байсныг дутуу илтгэснийг шүүмжлэгч бичжээ.

Ц.Лоохууз Д.Дамбын тухай шүүмжлэхдээ түүний албан тушаалдаа хэрхэн ханддаг байдлыг тодорхой баримтаар нотлон дурдсан байдаг. Тухайлбал, "...Д.Дамбын илтгэлд төрийн удирдлагад хамтын удирдлага хэрэггүй, тэнд дангаар захирах явдлыг бэхжүүлэх мэтээр илтгэж байна. ...төрийн удирдлагад хамтын удирдлага хамаарахгүй мэт хэлдэг нь юу гэсэн үг вэ? Манай төр ардчилсан төр бөгөөд ажил хэргээ олон түмэн сонгогчдын хяналтын дор явуулдаг жинхэнэ ардчилсан төр биш билүү. Сайд нарын Зөвлөл, Улсын Их Хурлын сонгуулийг яаж манай ардчилсан үндсэн хуулийн үндсэн шаардлагыг яах гэж байгаа хэрэг вэ? ...Манай намын удирдах нөхөд олон түмний гүн дунд орж ажиллахгүй, орон нутгийн байдлыг тодорхой судлахгүй, орон нутгийн намын байгууллагыг ажлын тодорхой бүтээлч аргад сургахгүй байна. Манай удирдах нөхөд хөдөө яаж ажилладгийг Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга н.Дамбын байн байн хөдөө явдаг замын зардлаас ч мэдэж болно. Нөхөр Дамба баруун зүг явахдаа Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ зэрэг олон аймгуудыг нэг захаас нь нөгөө хүртэл сар хүрэхгүй шахмын дотор байн байн явж өнгөрдөг. Энэ их газраар ийм хугацаанд хүнтэй уулзан, юу судалж ямар бүтээл гаргаж явдаг юм бэ? Нөхөр Дамба 1955 онд Говь-Алтай аймагт хоёр удаа очсон, тэгээд аймагт ямар нөлөө үзүүлсэн бэ? Дамба гуай яаруу сандруу явж байсан нь ажилтай танилцах ажиллах байтугай, тэр ч байтугай Дамба даргыг аймгийн төв дээр түүнийг үзэхээр хэдэн зуун хүмүүс цугларан дагаж байгаад ядахдаа тэдний даган байгаад ядахдаа тэдний зүг зөөлнөөр хандан сайн байна уу сайн ажиллаарай гэж хэлэх ч үг дуугүй суугаад байх юм. Гурван сумын төв дайрч өнгөрөөд хөдөө буудалд хоноод ар өврийн суман дээр буугаагүйгээр барахгүй, Цогт сумын нутаг бол тахал гарч байсан тул зогсох хэрэггүй түргэн явж өнгөрнө гэж өнгөрч байх жишээтэй. Хэрэв түүнийг тэд мэдсэн бол хичнээн гомдоох байсан бэ, мэтээр хувийн зан чанар болон жирийн хүний бодсон ч ийм олон аймгаар явахдаа сум бүрээр орох ёстой хэмээн байр сууринаас шүүмжилсэн нь үзэгдэнэ. Бас хэдэн мөрийн дараа "...нөхөр Дамба бодохдоо намын хороодыг ЗХУКН-ын ТХ-ны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургууль төгссөн хүмүүсээр дүүргэж авбал тэд тэнд хамаг ажлыг хийнэ, Төв Хороо ч яахав, хэсэг чадвартай хүмүүстэйгээр санаа амран сууж болно гэж боддог юм шиг байна. Хэрэв тийм бол буруу бодож байгаа нь тэр" хэмээн өгүүлсэн үзэгдэнэ.

Ц.Лоохууз Ю.Цэдэнбалын тухайд: "Ерөнхий сайд Цэдэнбал ч гэсэн сүүлийн жилүүдэд хөдөө явахдаа бараг больжээ. Намын 12-р их хурлаас хойш хөдөө тэнд явж байна гэж сонсоогүй. Харин СССР-т явж байна гэнэ, удаан хугацаагаар явж их ажил бүтээж байна гэж дуулддаг. Их ажил бүтээсэн тул сайшаасугай гэсэн УТТ-ны тогтоолууд ч үзэгдэж байх юм. Эх орны хөгжилд хэрэгтэй зүйлс хийж явна гэдэгт бид итгэж байдаг. Харин чухам юу хийсэн нь надад мэдэгдэхгүй байна. ...ганц Ерөнхий сайдыг бурхан шиг тахиж түүнийг олон түмний хяналтаас гаргана гэдгийг шинээр сурталчилж байгаа хэрэг биш үү"... Ерөнхий сайдыг ингэж тахиж суух нь нөхөр Дамбад өөрт нь л хэрэгтэй юм биш бол асуудлыг ингэж ардын ардчилсан төрийн шинжийн эсрэг хандуулан тавьж болохгүй"<sup>7</sup>. ... Нөхөр Цэдэнбалд манай нам, ард түмэн их итгэл хүлээлгэсэн. Цэдэнбал бол манай хувь заяаг шийдвэрлэж байна гэж итгэдэг. Тэгээд нам улсын ажилд гар бие оролцох талаар манай зарим сэхээтнүүд биеэ чөлөөлж байдаг юм. Магадгүй арваад жилийн өмнө таны ажил дээр санал зөвлөлгөөн өх үндсэний шинэ хүчнүүд ховор байж, харин бүх асуудлыг та голлон шийдвэрлэхэд хүрч байсан байж болох юм. Тэгвэл өнөөдөр өөр болжээ.

<sup>7</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-216-217

Манай нам өөртөө зохих тооны зохих мэдлэгтэй шинэ хүчнүүдийг төрүүлж авсан байна. Хэрэв тэдний дотор орж ажиллавал тэдэнд зохих итгэл хүлээлгэвэл тэд манай эх орны хөгжлийг түргэтгэхэд мэдлэг авьяасаа дайчлах зоригтой байгаа гэж үзнэ. Ганц хоёр хүнд бүх талаар итгэж, хамаг найдварыг хүлээлгээд олон түмэнтэй нягт холбоогүй байх нь ялангуяа удирдах хүнд өөрт нь ямар хортой Сталины гашуун туршлага үзүүлж байна”<sup>8</sup> хэмээн түүний ажлын алдаа дутагдлыг илчилж, эх орныхоо хөгжлийн төлөө санаа зовнигч нийгмийн шинэ хүчин нэгэнт бэлтгэгдэн гарсныг анхааруулсан байна. Түүнчлэн “...манай удирдах нөхөд олон түмний хяналт, олон түмний өмнө хүлээсэн хариуцлагаа дутуу үнэлж олон түмэн, доод хүмүүсээ тоож ярих, зөвлөхгүйгээр ганц нэг идэвхитэн хүмүүсийн амыг харах тал байгаа”-г илчлэн шүүмжилсэн юм. Мөн намын ардчиллыг зөрчиж байгаатай эвлэрч чадахгүй байгаагаа: “...Түүнчлэн УТТ-ны гишүүн Лхамсүрэн, Дүгэрсүрэн нар улс төрийн товчооноос шийтгэгдлээ гэж сонссон. Энэ юунаас болсон, үүний учрыг бүгд хурлын гишүүд сонсохыг хүсэж байгаа байхаа. Эд бүгдтэй холбогдуулан хэлэхэд намын амьдралын чухал асуудал намын удирдах ажилтнуудын алдаа дутагдлуудыг ТХ-ны хяналтнаас нууж байдаг явдал бол нэг хүнийг тахиж шүтэх илрэл, намын ардчиллыг бүдүүлгээр зөрчсөн хэрэг гэхээс өөр юу гэх вэ?” гэх мэтээр өгүүлсэн байна. Ерөнхий сайдыг сонгох болон УТТ-ны гишүүн Лхамсүрэн, Дүгэрсүрэн нарт хандсан дээрх шүүмжлэлээ тэрбээр “Ерөнхий сайд Цэдэнбал болон бусад удирдагчдын нэр хүндийг бууруулахыг бодсоноос хэлж байгаа хэрэг огт биш”<sup>9</sup> хэмээн тодотгожээ.

Басхүү “НТХ-ны зохион байгуулалтын удирдлагын гол асуудал бол шинэ хүчний асуудал мөн” гээд энэ талын ажил маш хангалтгүй явагдаж буйг намын удирдлага өөртөө хүлээх хэрэгтэйг ч нэгэн адил хамруулан авч үзжээ. Тухайлбал: “...шинэ хүчний асуудлыг муу эрхэлж байна. НТХ-ны аппаратыг бэхжүүлэх, сонирхолгүй байна. НТХ-ны аппарат маш чадваргүй, намын ажилд туршлага дадлага, бүх төрлийн сайн мэдлэгтэй кадрүүд цөөхөн, намын практик ажиллагаа, онолын талаар Төв Хорооны шаардлагыг хангаж чадахгүй сүрхий хоцрогдсон хүмүүс бас зусар бялдууч этгээд, нам эх орны хөгжлийн төлөө бага санаа тавиад дундыг баримталж бөөрөнхийлж, амь аргалж явдаг хүмүүс нэлээд байна. Хөдөө, удирдах ажилдаа тэнцэхгүй болсон хүмүүсийг ТХ-ны аппаратад авчирч суулгадаг, ингэж байхад тэд хөдөөгийн намын байгууллагыг яаж удирдаж чадах вэ? Эд НТХ-ны нэр хүндийг яаж хамгаалж чадах билээ. Шинэ хүчний ажилд тавихдаа эхлээд практик ажилд сургахгүй, сургуулийн танхимаас шууд удирдах том тушаалд тавьж байна. Энэ нь туршлагагүйдэхийн бэрхшээлийг тэдэнд олгож, тэд амьдрал мэдэхгүй хүмүүс болдог байна. Ер нь хүмүүсийн санаачлага ажлын дадлага, зан чанарыг судлахгүйгээр оросоор л бичдэг бол хэн ч байсан удирдах том тушаалд тавьдаг заншил нэг үе бараг моод болсон, миний бодоход энэ бол албан хэргийг явуулдаг албан ёсны хэл байхад заавал орчуулгыг маш өргөн хэрэглэж байдаг нь юунд хэрэгтэй юм бэ? Энэ чинь илүү бичиг цаасны ажил биш үү? НТХ-г хамгийн шилдэг хүчнээр дүүргэхгүйгээр яаж намын улс төрийн удирдлагыг амьд болгох билээ” гэж чадварлаг боловсон хүчинтэй байхын чухлыг анхааруулжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлд намын зохион байгуулалтын удирдлагын дутагдлыг гүнзгийрүүлэхэд манай удирдагчид ард түмнээс тасархай, орон нутгийг судлаж мэддэггүй, бүх талын мэдлэггүй байгаа нь ихээр нөлөөлж байгааг тэмдэглээд “Удирдах хүмүүс, доорд хүмүүс олон түмнээс тусгаарлавал намыг аюулд оруулна. Манай удирдах нөхдийн ажиллах, амьдрах, зарим нөхцлийн ч тэднийг ард түмнээс тусгаарлаж байхад зоригдсон байдаг байна. Ганц нэг жишээ хэлэхэд: Манай удирдагчид намын их хөрөнгөөр жил бүр

<sup>8</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-219-221

<sup>9</sup> Мөн тэнд.т-212-213

гадаадад явж амардаг болжээ. Амрахыг буруу гэж байгаа бишээ. Манай эх оронд удирдагчдаа амруулах сайхан байгаль алга гэж үү? Бид түүнийг байгуулж чадахгүй юм гэж үү? Энэ бол эх орноо гомдоосон хэрэг, хэрэв хэрэгтэй юм бол, бид намын гишүүд, ямар ч сайхан амралтыг байгуулж өгч болно. Бас ямагт тусгай дэлгүүр, тусгай эмнэлэг, тусгай байр, тусгай гуанзтай байдгаас ард нийтийн амьдрал байдал, наад захын үйлчилгээний зүйлүүдийг ч мэдэж сонирхох өдөр тутмын бололцоо алга. Манай удирдагчид аливаа хурал, баяр ёслол дээр ч гэсэн хүмүүстэй уулздаггүй, тэдний дунд орж ярьдаггүй, тусгай хаалгаар л, тусгай өрөөнөөс л таазан дээр алга ташуулан гарч ирээд олонхи хурлууд дээр байн байн кино, фотод зургаа авахуулж суух нь их харагддаг. Гэтэл тэднийг харж баясахаар буй олон түмэн үзэгч олныг кино зурагт авахуулахыг шаарддаггүй. Энэ бүгд бол «*өөрсдийгөө олон түмнээс маш өөр ангид үнэ хүндтэй тусгай хүмүүс*» гэж өөрийгөө шүтэх онолыг л ажил хэрэг дээр хэрэгжүүлж буй хэрэг даруй мөн<sup>10</sup> хэмээн удирдагчид олон түмний амьдралыг мэдэхгүй нийгмээс тасархай байгааг шүүмжилжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлийн нэлээд дэвшилттэй тал нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болох хэвлэл, радио, урлаг, утга зохиол ихээхэн мохоо, эдгээрийн агуулга тухайн үед тохирохгүй байгааг шүүмжилсэн явдал юм. Тэрээр "Манай ард түмний амьдрал, манай эх орны хөгжлийн амин чухал асуудлуудыг тун бага нэвтрүүлж, дэвэн дэлхийн юм гадаадын материалыг гол болгон нэвтрүүлэх, бичих нь их байна. Манай урлаг, утга зохиол, ардын сэтгэл санааг хөдөлгөн тэднийг бүтээн босгох ажилд дайчилж чадахгүй байна. Урлаг утга зохиол нь олон түмэнд ойлгомжтой, тэдний чих тавин сонсож, сонирхдог урлагийг хөгжүүлэхэд бүрэн чиглэгдэж чадахгүй байна. Манай ард түмэнд ойлгогдохгүй гадаадын дуунуудыг л байнга нэвтрүүлж байдаг болжээ. Манай малчид Чайковский, Моцартыг ойлгох арай болоогүй байна. Хэрэв хотын ойлгодог сэтээтнүүд эдгээрийг сонсож байх нь чухал гэж үзвэл тэдэнд тусгай радио шугамыг байгуулж өгвөл таарах юм" гээд Зөвлөлтийн соёлоос сурах хэрэгтэй ч гадаадын орны соёлын хэлбэр маягуудыг ямар ч бодолгүй хуулан дэлгэрүүлэх нь чухал бишийг "...манай урлагийн индрийн нэлээд зайг гадаадын дуу, хөгжим эзлээд манай ардын зүрх шимшрэн дурладаг дуу хөгжмүүдэд бага зай ногдож байна"<sup>11</sup> гэсэн шүүмжлэлээр жишээлэн өгүүлжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлд үндэсний хэл, урлаг, соёлоо хөгжүүлэх асуудал дээр анхаарахгүй бол болохгүйг "Манай ардын нэрийг зүүсэн жүжигчид хэн байна вэ? Улаанбаатарынханд голдуу дуулагддаг, тэдний өмнө голдуу дуулж тоглодог, олон янзын хэл дээр дуулах дуртай хүмүүс л манай ардын жүжигчин, гавъяат жүжигчний нэрийг хүлээж байна. Гэтэл манай ард түмний гол олонхийн дурладаг дуучин, хөгжимчин нар ардын цол зүүх байтугай нэр нь бараг гарахгүй байна. Манай урлагийн тайзны албан ёсны хэл бол халх хэл. Сүүлийн үед театрын тайзан дээр тоглодог концертыг заавал монгол, орос, хятад хэлэн дээр явуулах болжээ. Энэ чинь хэнд хэрэгтэй, юунаас шаардагдах хэрэгтэй болсон юм бэ? Магадгүй энэ ажлыг эрхэлж буй хүмүүс хариулахдаа манайд орос, хятад хүмүүст бийгээс ийм болсон юм гэх гэж байгаа байх. Бас театрын тайзан дээрээс гурван улсын найрамдлыг харуулах гэж буй улс төрийн бодлого гэж харуулах гэж байгаа байх. Тэгвэл энэ чинь тэр зорилгуудын аль алиныг хангаж чадсангүй, чадах ч үгүй. Энэ чинь хэрэг дээрээ бид манай оронд байгаа гадаадын хэдхэн тооны мэргэжилтэнтэй тэдний мэддэг хэлээр нь харьцаа бариад өөрийн ард түмэнтэй орчуулагчийн тусламжтай харьцана гэсэн хэрэг болон хувирч байна. Манай хэлийг театрынхаа тайз, радио узелдээ бараг албан ёсны хэл мэтээр хэрэглэж байгаа эсэхээр чинь та нарыг манай найрамдалд үнэнч байгаа эсэхийг шалгана гэж манай үнэнч хань СССР, Хятад хэлж биднийг

<sup>10</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.т-221-223

<sup>11</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.т-225-226

сүрдүүлээгүй байна. Тэд тэхгүй /тэгэхгүй. Б.Б/ гэдэгт тун хатуу итгэж байна"<sup>12</sup> гэсэн саналыг хөндөн тавьжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлд социализмын тухай намд онол хэрэгтэй ба ирээдүй хойчоо бодох талаар ч санаж сэдсэн түүхэн сургамжийн чанартай, нэлээд сонирхолтой гаргалгаа хийсэн зүйлүүд бий бөгөөд тэдгээрээс цухас дурдвал: "...Социализмд алхсан орон өөр өөр хэлбэрээр үндэснийхээ онцлог байдлыг харгалзах ёстой гэсэн коммунист намын XX их хурлын дүгнэлт хийснийг дахин сайн уншъя. Коммунизмд орос оросоороо, хятад хятадаараа, монгол монголоороо орох болно. Харин коммунизмын үед аль улс ямар хэлтэй байх асуудлыг одоо шийдвэрлэхийг түүх бидний өмнө тулгаагүй байна. Энэ бол түүхээр бидний өмнө тавигдсан зорилго хараахан биш. Энэ бол бидний хойч үеийнхний зорилго мөн. Бидэнд түүх өөр тодорхой зорилго тавьжээ. Бидний зорилго бол хойч үеийнхэндээ тохилог орон сууц, үйлдвэрийн газрууд барих, тэдний хэрэгцээг хангаж чадахуйц өндөр ашиг шимтэй малыг бий болгох явдал юм. Энэ зорилгыг гагцхүү одоогийн ардын ярилцдаг хэлний тусламжтайгаар гүйцэтгэх болно. Тэгвэл одоо үндэснийхээ хэлийг хөгжүүлэх хэрэгтэй"<sup>13</sup> гэсэн байна. Мөн манай орны хөгжлийг сурталчилахдаа хувьсгалын өмнөх байдалтай харьцуулж байгааг шүүмжлээд "...сүүлийн үед манай орны хөгжил ихээхэн удаан явж байна гэж шүүмжлэн үзэх сэхээтэн олширсон учир тэднийг эх орныхоо хөгжлийг тоодоггүй, өөрийн орны онцлогийг мэддэггүй хүмүүс гэж буруушаасан"-ыг хэлэхийн хамт "...бид ардын хувьсгалын 35 жилд олсон их ололтыг хамгийн хоцрогдсон феодалын монголтой зэрэгцүүлээд сууна гэдэг бол хэрэг дээрээ хоцрогдолтой ойр байна гэсэн хэрэг болж байна"<sup>14</sup> гэсэн анхааруулгыг өгчээ. Цааш нь манай намд улс орныг удирдах онол байхгүй байгааг шүүмжлээд, Өнөөдөр, манай намын онолын хэмжээ ямар байна вэ? гэсэн асуудал дэвшүүлж, "...Манай намын онолыг боловсруулах асуудлыг НТХ-ны анхааралд хандаагүйгээр барахгүй түүнийг эрхлэн оролддог сэхээтэн ч үгүй болж байна. Онолоо боловсруулаагүй марксист ямар ч нам байхгүй. Бусад орны туршлагыг харахад онолоо боловсруулахад сэхээтнийг өргөн оруулдаг, нам өөртөө энэ асуудлыг гардан эрхэлдэг, марксист онолыг ч хөрөнгөтний сэхээтнүүд боловсруулсан шүү дээ. Манай улсын үйлдвэрлэх хүчний одоогийн хөгжлийн хэмжээ байгаль нийгэм, техник, тодорхой шинжлэх ухааны ололтууд хэдий бага байгаа боловч боловч намын онолыг боловсруулах ажлыг эрхлэх бололцоотой болгож байна. Гэтэл НТХ сэхээтнийг намын онолыг боловсруулах ажилд оруулах байтугай энэ ажлаас хөндийрүүлж байна. Манай сэхээтнүүд, намын онолыг боловсруулах асуудалд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байна. Гэтэл манай намын удирдах нөхдөөс энэ хүслийг тоомсорлон үзэхгүй байгаа учраас намын нэртэй холбоотой онолын алдааг гаргахад хүрч байна. Хувийн аж ахуйтныг төлөвлөгөөжүүлэх, алдааг гаргахын урьд манай сэхээтний талаас энэ болохгүй, марксизмд хувийн өмчтөнийг төлөвлөгөөжүүлэхийн эсрэг байдаг гэж хэлж байсан хүн бий байхаа. Энэ сануулгыг сонсоогүйгээр барахгүй, үг саналаа хэлсэн хүн ч зэмлэлгүй өнгөрч чадаагүй байхаа"<sup>15</sup> хэмээсэн их төлөв асуулгын чанартай, өргөн утга бүхий шүүмжлэл тавьжээ.

Ц. Лоохуузын шүүмжлэлд улс орноо цаашид яаж хурдацтай хөгжүүлэх талаар санаа тавьсан шинэлэг санал бодолтой хүмүүсийг дэмждэггүй тухайд: "1953 онд хэсэг сэхээтнүүд, манай эх орны цаашдын хөгжлийн төлөө санаа зовсон хэд хэдэн статяаг Ерөнхий сайд нөхөр Цэдэнбалыг гадаадад явж байсан хугацаанд бичсэн. Тэгээд тэр нь намын гишүүдийн сонирхлыг ихээр татаж, тэднээс эх орны хөгжлийн тухай ярьж хэлэлцэхээр ихээхэн бодож байсан

<sup>12</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.. т-226-227

<sup>13</sup> Мөн тэнд. т-228

<sup>14</sup> Мөн тэнд. т-227-228

<sup>15</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1..т-230

бодолд дэмжлэг болсон юм. Гэтэл НТХ-ны зүгээс энэ үзэгдэлтэй яаж хандсан бэ? ТХ-ны нарийн бичгийн дарга нарын зүгээс статяа бичигчдийг цаг нь болоогүй юм бичсэн, бичих ч хэрэггүй, та нар ч бичдэг нь биш гэх шахуу юм хэлж тэд сэхээтний зоригийг мохоон үзгийг нь хураалгасан. Түүнээс хойш нэг ч хүн зориглож юм бичсэнгүй. Гэвч манай сэхээтнүүд манай орны ирээдүйн тухай, одоогийн тухай онолын талаар нам, улсын хэвлэлд бичиж болдоггүй юм бол «*толгойныхоо эсэн дээр бичиж байя*» гэж шийдсэн байхаа<sup>16</sup> гэж улс төрийн тодорхой шалтгааны улмаас олон ургалч үзлийг хаан боогдуулж байсныг ч зоригтой илчлэн шүүмжилжээ. Бас "...намаас онолын асуудалд анхаарал тавихгүй байгаагаас манай хөгжилтэй холбогдсон маш олон чухал асуудал бүрхэг, тайлбаргүй байсан хэвээр байгаа нь манай орны хурдан хөгжилтөд ихээхэн саад болж байгааг тэмдэглээд, зохистой хэрэглээ ч ихээхэн доголдож буйг мөн шүүмжилжээ. Тухайлбал, "Манай аймагт 10 шахам мянган ширээний цагийн хэрэгцээ байна. Гэтэл 1956 оны улсын гадаадаас авах ширээний цагны тоо дөнгөж 3000 байна. Өнөөдөр Говь-Алтай аймгийн байдлаар сум бүрт 20, 30-с доошгүй тонн гурилтай байна. Багуудаас дан гурил ачуулж байна. Одоо ганц Толгойтын бааз дээр хэдэн жилийн дотор хуримтлагдсан 17 мянган тонн гурил байна. Энэ гурилын үнэ цагаан будааны үнэтэй тэнцэх гэж байна. 300 тонн шар будааны үнэ нь аль хэдийн нэгдүгээр гурилын үнэнд хүрчээ. Манай ардууд өргөн хэрэглээний бараагаар хангагдаад магадгүй хэдэн сар буюу жилийн запастай болсон юм шиг хөдөөний надад санагдаж байна. Гэтэл нарийн барааны хэрэгцээ хичнээн их байна вэ? Энэ талаар цангаж байна. Ийм асуудлыг НТХ яагаад анхаарахгүй байна вэ"<sup>17</sup> хэмээн өгүүлжээ.

Шүүмжлэлд олон түмнийг нийтийн хөдөлмөрт татан оролцуулах явдал чухал байгаа талаар бичихдээ: "...Өнөөдөр хөдөлмөрийн тухай сурталчилах, хүн амыг хөдөлмөрт дуртай болгох, сургах асуудал тус оронд социализмыг байгуулахтай шууд холбоотой асуудал юм. Яагаад манайд хөдөлмөрийн тухай асуудал онц хэрэгтэй болов. Бид феодализмаас социализмд орох гэж буй. Гэтэл социализм бол асар их өндөр ухамсартай, хөдөлмөр дээр тулгуурладаг тийм хөдөлмөр шаарддаг байна. Капитализм бол феодализмаас хөдөлмөрийг үзэн ядах ёсыг эвдэж, хүмүүсийг хөдөлмөрт сургах талаар социализмд ихээхэн бэлтгэл болдог байна. Ингэхлээр бид социализмыг барихад шаардагдах ухамсартай хөдөлмөрт хүмүүсийг сургах асар их бэлтгэлийг энэ үед тухайлбал социализмын материал техникийн бааз байгуулж бий энэ үед гүйцэтгэх хэрэгтэй болж байна. Хэрэг дээрээ өнөөдөр хөдөлмөрийг ёстойгоор үнэлэх үзэл нийтэд шингээгүй феодалис ёсоор үзэх үзэл маш гүнзгий байна"<sup>18</sup> гэсэн бүтээлч шүүмжлэлийг өрнүүлжээ.

Дурдан буй үед нийгмийн амьдрал, тэр дундаа ядуу өрхийн тухай өгүүлсэн шүүмжлэлдээ тэрбээр: "Говь-Алтай аймгийн намын хороо 10 хүртэл бодтой аж ахуйтныг ойрын жилүүдэд 10-с дээш бодтой болгож, тэдний амьдралыг дээшлүүлэхийг эрмэлзэн ажиллаа. Гэтэл энэ бодлого маш удаашралтай биелэгдэж байна. Яагаад гэвэл судалж үзсэн тийм аж ахуйтны олонх нь их хэрэглэх дуртай атлаа залхуурах, «*мөр бүтэн, гэдэс цатгалан*» явбал боллоо гэж үздэг хүмүүс дайралдаж байх юм. Ер нь манайд одоо үед хүмүүс ядуурч хоосрох нийгмийн шалтгаан алга. Хүмүүсийг хөдөлмөрт сураагүй, хөдөлмөрийг ёстойгоор эрхэлж чадаагүй байгаа явдал нь нэлээд хүмүүсийг ядуу амьдрагч шалтгаан болж байна. Ядуу аж ахуйтнуудад илүүдэл хүчин нэлээд их байна. Манай эх орны үйлдвэрүүд энэ аж ахуйтнуудаас ачилчны бэлтгэл хүчнийг авч байна. Энэ нь манай ажилчин ангийн хатуужил, чанар хөдөлмөрийн бүтээлд бас л бэрхшээл учруулах нь дамжиггүй. Энэ бол НТХ-ны

<sup>16</sup> Мөн тэнд. т-231

<sup>17</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.т-233-234

<sup>18</sup> Мөн тэнд. т- 234-235



өнөөдрийн үзэл суртлын гол асуудлын нэг байх ёстой байна. Энэ мэт ноцтой асуудал манай намын ажлын бүх салбарт байгаа юм. Зарим нөхөд сул дутагдалтай ярьж байна. Намын сонирхол, эх орны хөгжлийн сонирхол, намын гишүүдийг зогсоохгүй байж болохгүй байна. Магадгүй зарим нөхөд болгоомжилж дутагдлыг ил тавихаас айж байх шиг байна. Бидэнд намын хэргийн төлөө өргөн хараагаар харахыг ЗХУКН туслаж бидний нүдийг нээж байгаа тул Зөвлөлтийн коммунистуудад тус бүгд хурлаас баяр хүргэх санал тавьж байна"<sup>19</sup> хэмээсэн зөв зүйтэй шүүмжлэл тавьжээ. Ц.Лоохууз өөрийн шүүмжлэлийн төгсгөлд: "Би тус бүгд хурал дээр манай НТХ-ны УТТ-нд болон ялангуяа түүний зарим гишүүдэд байгаа дутагдлыг шүүмжлэхдээ манай намын ажлыг сайжруулахаас өөр ямар нэгэн агуулгыг хадгалаагүй. Миний хэлсэн зүйлийг гагц би санасан билээ. Би «зоригтой сайндаа, эр чадалтайдаа биеэ тоосондоо, эрх тушаал горьдсондоо» биш юм. Магадгүй зарим нөхөд миний шүүмжлэлийг сонсоод тэгж бодож байж болох юм. Тэгвэл тэдгээр хүмүүс өөрийгөө би бол хувийн нэр алдар, эрх ямбыг намын сонирхол, эх орны хөгжлийн сонирхлоос өндөрт үздэг хүн юм байна гэдгийг хамт хийгээрэй гэж хэлмээр байна" хэмээн шүүмжлэлээ дуусгажээ.

Эл шүүмжлэлийг хүмүүс хэрхэн хүлээж авсныг товч өгүүлье. Хожим нь "намын эсрэг бүлэг" гэгчид хамт хэлмэгдсэн Бандийн Сурмаажав (НТХ-ны үйлдвэрийн хэлтсийн дарга): Лоохуузын шүүмжлэлийн талаар нэг үг хэлэх ёстой. Лоохуузын шүүмжлэлд национализм нэвт ханхалж байна. Лоохууз Төв Хороонд байхдаа орчуулга хийж мөнгө хөөцөлддөг байсан хувийн ахуйн талаар ёозгүй нөхөр байгаа юм. Лоохуузын шүүмжлэлийн ёозгүй тал нь юу байгаа вэ гэвэл, Лхагважав гэдэг эмэгтэйгээр тоглоом хийгээд тэр Улс Төрийн товчооноос санамж аваад түүндээ өшиж хариу бодсон хэрэг. Ерөөс Лоохуузын шүүмжлэл хоёр талтай. Сайн талыг нь шилж аваад нөгөө талаар нь анхаарах хэрэгтэй"<sup>20</sup> хэмээн бичжээ. Энэ шүүмжлэлээс харсан ч хүмүүсийн ярианаас сонссон ч Ц.Лоохууз Лхагважав гэдэг эмэгтэйтэй ханилан сууж байгаад салсан нь үнэн бололтой ба Б.Сурмаажавын хэлсэнчлэн өшиж хариу бодсон хэрэг бус байх гэж үзэж байна. Лоохуузын шүүмжлэлийн зарим талыг буруушаасан хүний нэг нь Аж үйлдвэрийн яамны сайд Бавуудорж юм. Тэрбээр: "...Цэдэнбал, Сүрэнжав хоёрын хэнийг нь Ерөнхий сайдын тушаалд тавих явдал дээр Төв Хорооны УТТ-нд санал зөрөлдөөн гарч байсан юм шигээр ярьж байна. Лоохууз үүнийг яаж мэдсэн юм бэ? Лоохууз Цэдэнбалд улс төрийн анхааруулга өгч байв. Анхааруулга өгөхөөр юу болсон юм бэ? Гадаад бодлогод алдаа хийснээс Монгол Улс НҮБ-д ороогүй байгаа гэсэн Лоохуузын шүүмжлэл бүр ч алдаатай байна"<sup>21</sup> гэж Ю.Цэдэнбалд ая тал зассан үг хэлсэн байна. Ц.Лоохуузын талаар шүүмжилсэн дээрх шүүмжлэлээс харахад түүний хэлсэн үгийг мушгин гуйвуулсан зүйл ч ажиглагдаж байна.

Харин бүгд хурлын төгсгөлд МАХН-ын Төв Хорооны I нарийн бичгийн дарга Д.Дамба: "Лоохуузын шүүмжлэл зүйтэй. Ийм дутагдал манайд байна. Ард түмний аж амьдрал дорой байгаа. Шүүмжлэлийн дагуу шалгаж, арга хэмжээ авах нь зүйтэй" <sup>1</sup> гэсэн зөрүү үг хэлжээ. Үүний дараа Ю.Цэдэнбал: "Нөхөр Лоохуузын шүүмжлэлийг цөмийг буруу гэж хэлэхгүй. Түүний ихэнх нь зөв юм. Ялангуяа Лоохууз шинэ хүчний асуудлын талаар халж сольдог, шилж авах явдал сул гэсэн нь бүр зүйтэй байна. Танил талыг харах, бялдууч зусарч хүнийг ажилд авах явдал үзэгдсээр байна. Гэхдээ түүний шүүмжлэлд национализм нэвт ханхалж байна гэж Сурмаажав зөв хэлсэн. Лоохууз орос дуу, хятад дуу, мөн гадаадын ямар нэг дуунуудыг гол болгоод өөрийнхөө юмыг харж үзэхгүй

<sup>19</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1.235-236

<sup>20</sup> Мөн тэнд. Т-246-247

<sup>21</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-1. т-261

<sup>1</sup> Монгол улсын түүх. V боть. УБ., 2003. т-288

байна гэнэ. Магадгүй манай урлагийн газруудын үзүүлж буй зүйлд монгол үндэсний юм цөөхөн байж болох юм. Чойжамц (Урлагийн хорооны дарга) ч үүнийг хүлээж авсан. Тэхдээ бусад орны, хань нөхдийнхөө соёлыг хүндэтгэхгүй байж болохгүй. Түүнчлэн Лоохууз орос хэлэн дээр хамаг тогтоол зэргийг хийж байхын хэрэг юу вэ гэж хэлж байна. Бүх тэргүүний соёл энэ хэлэн дээр бичигдэж байна. Бид коммунизм байгуулж байгаа тэр их орны хэлийг судлах хэрэгтэй. Орос хэлийг хэрэглэж болохгүй гэх явдал байж таарахгүй. Эх оронч хүн гэдэг бол интернационалист байх ёстой. Бусад орны соёлыг хүндлэхгүй бол яаж эх оронч байж чадах юм бэ? Энэ мэт шүүмжлэлд дэгсдүүлэх явдал байна. Тэр нь өөрсдөд нь сургууль болох бизээ”<sup>1</sup> гэж сургамжийн чанартай үг хэлжээ.

Ц.Лоохуузын шүүмжлэлийг бүхэлд нь нэгтгэн үзвэл нэг хүнийг тахин шүтэж байсны хор уршгийн цаад учир шалтгааныг илрүүлэн улмаар арилгах, улс орноо түргэн хурдацтай хөгжүүлэхэд сэхээтний хүчийг ашиглах, үндэсний хэл, урлаг, соёлоо хөгжүүлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ард түмэнд ойртуулах, Ерөнхий сайд болон УТТ-ны гишүүдийн хэт дураар авирлах явдлыг хязгаарлах гэсэн өргөн утга бүхий шүүмжлэлийг зоригтойгоор илчлэхийн сацуу хойч үеийхнийхээ өмнө хүлээх өндөр хариуцлага буйг ч анхааруулжээ. Эл шүүмжлэл нь Монголын нийгэм дэх улс төрийн амьдралд шинийг эрэлхийлэгч тэргүүний хүмүүс төрөн гарч буйг харуулсан, тухайн үеийн нийгэм-оюун санааны амьдралд ардчилал, олон урьгалч үзэл, улс төрийн шинэ сэтгэлгээгээр хөгжүүлэхийг эрмэлзэн байсан үзэл санааны тусац байсан билээ.

Энэхүү өгүүлэл бол Ц.Лоохуузын тухай судлагааны эхлэл бөгөөд цаашид түүний улс төрийн үйл ажиллагааг гүнзгийрүүлж, цаг хугацааны дарааллаар буюу 1957-1964 оны бүгд хурал, бусад хурал зөвлөгөөнд түүний хэлсэн үгийг нарийвчлан авч үзэх болно.

**Abstract:** The article aims to clarify Ts. Loohuuz's criticism on Mongolia's socio-political situation of the 1950s. First, his criticism focuses on the country's one of the controversial issues of the period: the cult of Choibalsan. In this regard, Loohuuz urged the government officials to take measures in order to disclose the cause of the cult of Choibalsan. His main concern was the issue of the economic development of the country. In order to develop the country rapidly Loohuuz proposed to mobilize the national intelligentsia. In addition, he also urged to encourage and support Mongolia's national culture and art instead of broadcasting foreign songs, music and etc.

By examining Loohuuz's criticism, I reached to a conclusion that Loohuuz was one of the representatives of Mongolia's new generation of intelligentsia who aimed to develop and democratize the country

<sup>1</sup> МАХН-ын Төв архив. Ф-4, т-23, х/н-4. т-156